

2026 оны 06 дугаар сарын 12-ны өдөр

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль болон төрийн санхүү, хөгжлийн бодлого, ил тод байдал, иргэдийн оролцоог хангахтай холбоотой бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулав.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ...” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...” үүргийг хүлээхээр тус тус заасан. Төрийн төсөв нь нийтийн хөрөнгө, татвар төлөгчдийн орлогоор бүрддэг тул түүний төлөвлөлт, зарцуулалт нь ил тод, хариуцлагатай, үр ашигтай байх нь Үндсэн хуулийн үзэл баримтлалын салшгүй хэсэг юм.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д Улсын Их Хурал “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах” бүрэн эрхтэй байхаар заасан. Мөн уг зүйлд “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.”, “Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно.”, “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж тусгасан нь төсвийн төлөвлөлт, хяналт, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог хуульчлан боловсронгуй болгох суурь үндэслэл болж байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг хангасан байх зарчим, 27 дугаар зүйлд төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага, 28 дугаар зүйлд Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төлөвлөлт, 28¹ дүгээр зүйлд Төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах, 32 дугаар зүйлд Төсвийн төслийн танилцуулгын агуулгыг тус тус зохицуулсан боловч эдгээр зохицуулалтын хэрэгжилт бодит байдалд хангалтгүй, мэдээллийн хүртээмж, төсвийн эрэмбэлэлт, үнэлгээ, тайлагнах нэгдсэн тогтолцоо сул хэвээр байна.

ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Монгол Улсын төсвийн бодлого, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хөрөнгө оруулалтыг эрэмбэлэх аргачлал, хэрэгжилт, ил тод байдал, олон нийтийн

оролцоотой холбоотой эрх зүйн зохицуулалт сүүлийн жилүүдэд үе шаттайгаар боловсронгуй болсон хэдий ч төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, төсөл арга хэмжээний сонголт, төсвийн төлөвлөлтийн чанар, гүйцэтгэлийн сахилга хариуцлага, мэдээллийн нээлттэй байдал хангалтгүй хэвээр байна.

Төсвийн тухай хуульд улсын хөгжлийн бодлоготой уялдсан төсөв боловсруулах, хөрөнгө оруулалтын төсөлд урьдчилсан үнэлгээ хийх, олон нийтийн оролцоог хангах, төсвийн мэдээллийг нийтэд хүргэх суурь зохицуулалтууд тусгагдсан боловч эдгээрийг хэрэгжүүлэх нарийвчилсан шалгуур, эрэмбэлэх аргачлал, үнэлгээний нэгдсэн тогтолцоо, ил тод тайлагнах зохицуулалт бүрэн төлөвшөөгүй байна.

Нэг. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, эрэмбэлэх аргачлалыг боловсронгуй болгох шаардлага

Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эдийн засгийн өгөөж, нийгмийн үр нөлөө, бэлэн байдлын түвшин, санхүүжилтийн боломж, ашиглалтын дараах үр ашиг зэрэг шалгуурт үндэслэн эрэмбэлэх тогтолцоо сул байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашиг буурах, төсөвт өртөг нэмэгдэх, хэрэгжих хугацаа хэтрэх, дуусаагүй болон шилжих төслүүдийн тоо өсөхөд нөлөөлж байна. Үндэсний аудитын газрын дүгнэлтээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд туссан олон төсөл, арга хэмжээ нь бодлогын баримт бичиг, хөгжлийн төлөвлөгөөтэй хангалттай уялдаагүй, үнэлгээний шаардлага хангаагүй байна. Тухайлбал, орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 81.8 хувь нь Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй нийцээгүй, батлагдсан төслүүдийн үнэлгээний түвшин 0-55 хувьтай байсан талаар аудитын дүгнэлтэд тэмдэглэжээ.

Мөн 2024 оны Улсын төсөвт туссан нийт 1,049 төсөл, арга хэмжээний 52.6 хувь нь шилжих төсөл байсан бөгөөд төсөв батлах явцад энэ тоо 606 болж нэмэгдсэн нь төлөвлөлтийн чанар, хэрэгжилтийн бодит чадамж хангалтгүй байгааг харуулж байна. Түүнчлэн төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ сүүлийн жилүүдэд эрчимтэй өссөн боловч хөрөнгө оруулалтын өгөөж, үр нөлөөний үнэлгээ хангалтгүй хэвээр байна. Судалгаагаар 2020-2024 онд улсын төсвийн нийт зардал 13.9 их наяд төгрөгөөс 30.4 их наяд төгрөгт хүрч өссөн бөгөөд төсвийн хөрөнгө оруулалт 1.4 их наяд төгрөгөөс 3.1 их наяд төгрөг болж нэмэгдсэн байна. Мөн төсөл, арга хэмжээний сонголт, төлөвлөлтөд улс төрийн нөлөөлөл өндөр, эдийн засгийн үндэслэл болон бэлэн байдлын үнэлгээ хангалтгүй, эрэмбэлэлт ил тод бус байгаа талаар аудитын байгууллагууд болон судлаачид удаа дараа анхааруулж ирсэн. Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашигт сөргөөр нөлөөлж байна.

Иймд хөрөнгө оруулалтын төслийн сонголт, эрэмбэ, үнэлгээг нэгдсэн шалгуур, аргачлалд үндэслэн хэрэгжүүлэх, бодлогын баримт бичигтэй уялдуулах, төслийн үнэлгээ болон эрэмбийн талаарх мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Хоёр. Төсвийн урсгал зардлын ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлага

Улсын төсвийн урсгал зардлын хэмжээ сүүлийн жилүүдэд тогтмол өсөж, нийт төсвийн зарлагын 70 гаруй хувийг эзлэх болсон боловч түүний бүтэц, зориулалт, нэгж өртөг, үр ашиг, зарцуулалтын талаарх мэдээлэл олон нийтэд хангалттай нээлттэй, ойлгомжтой байдлаар хүрэхгүй байна. Тухайлбал, Урсгал зардал 2020 онд ойролцоогоор 10.8 их наяд төгрөг байсан бол 2025 онд 24 орчим их наяд төгрөгт хүрсэн байна. Урсгал зардлын өсөлт нь төрийн үйлчилгээ, цалин хөлс, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой боловч захиргааны зардал, чиг үүргийн давхардал, үр ашиггүй бүтэц,

шаардлагагүй худалдан авалт зэрэг эрсдэл байгааг аудитын байгууллагууд анхааруулсаар байна. Үндэсний Аудитын газрын тайланд урсгал зардлын төлөвлөлт нь гүйцэтгэлийн үр дүн, нэгж өртөг, зорилтот үр ашигтай хангалттай уялддаггүй, өмнөх оны зарцуулалтыг шууд үргэлжлүүлэн төлөвлөх хандлага түгээмэл байгааг дурдсан. Одоогийн зохицуулалтаар төсвийн төсөлд урсгал зардлын ерөнхий мэдээлэл тусдаг боловч зориулалт, нэгж өртөг, тоо хэмжээ, үр дүнгийн шалгуур, зорилтот бүлэг, өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулсан тайлбар зэрэг мэдээлэл хангалтгүй байна. Үүний улмаас иргэд, судлаачид болон хууль тогтоогчид төсвийн урсгал зардлын бодит хэрэгцээ, үр ашигт үр нөлөөтэй хяналт тавих боломж хязгаарлагдаж байна.

Олон улсын байгууллагууд төсвийн урсгал зардлыг байгууллага, хөтөлбөр, зориулалт, нэгж өртөг болон үр дүнгийн үзүүлэлттэй нь уялдуулан тайлагнахыг төсвийн ил тод байдлын үндсэн шаардлага гэж үздэг. Иймд урсгал зардлыг төсвийн захирагч бүрээр нарийвчлан ангилж, зориулалт, нэгж өртөг, тоо хэмжээ, нийт үнэ, үр дүнгийн үзүүлэлттэй нь уялдуулан олон нийтэд нээлттэй мэдээлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Гурав. Төсвийн үйл явц дахь олон нийтийн оролцоо, мэдээллийн хүртээмжийг сайжруулах шаардлага

Төсвийн тухай хуульд төсвийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, төсвийн танилцуулгыг нийтэд мэдээлэх зохицуулалт тусгагдсан боловч хэрэгжилтийн чанар, үр нөлөө хангалтгүй хэвээр байна. Бодит байдалд төсвийн төслүүд нь ихэвчлэн мэргэжлийн, хэт ерөнхий хэлбэрээр нийтлэгддэг бөгөөд иргэдэд ойлгомжтой тайлбар, харьцуулалт, дүрслэл хангалтгүй байдаг. Мөн олон нийтийн санал төсөвт хэрхэн туссан талаар эргэн мэдээлэх тогтолцоо сул байна. Олон улсын үнэлгээгээр Монгол Улс төсвийн ил тод байдлын үзүүлэлтээр ахиц гаргаж байгаа боловч иргэдэд зориулсан төсвийн танилцуулга, олон нийтийн оролцоо, төсвийн мэдээллийн ойлгомжтой байдал харьцангуй сул хэвээр байна. Төсвийн хэлэлцүүлгийн явцад хийгдсэн нэмэлт, өөрчлөлтийн үндэслэл, нөлөөлөл, санхүүгийн эх үүсвэрийн талаарх мэдээлэл олон нийтэд хангалттай нээлттэй хүрдэггүй байна. Мөн төсвийн төсөлд иргэд, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагаас ирүүлсэн саналын тоо, агуулга, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх нэгдсэн тайлан тогтмол хийгддэггүй нь олон нийтийн оролцооны үр нөлөөг бууруулж байна.

Олон улсын сайн туршлагаас үзэхэд төсвийн төслийг иргэдэд зориулсан хялбаршуулсан хэлбэрээр танилцуулах, төсвийн гол үзүүлэлтүүдийг ойлгомжтой тайлбарлах, олон нийтийн саналын мөрөөр тайлагнах тогтолцоог бүрдүүлэх нь төсвийн ил тод байдлын чухал шалгуур болдог. Монгол Улс Төсвийн нээлттэй байдлын судалгаагаар 2023 онд 100 онооноос 60 оноо авч, хязгаарлагдмал мэдээлэлтэй гэж үнэлэгдсэн бөгөөд иргэдэд зориулсан төсвийн танилцуулга, олон нийтийн оролцоо, төсвийн мэдээллийн ойлгомжтой байдал харьцангуй сул үзүүлэлттэй гарсан байна. Ялангуяа төсвийн төслийн шатанд иргэдийн оролцоог хангах, саналын мөрөөр тайлагнах, төсвийн өөрчлөлтийн үндэслэлийг ил тод тайлбарлах асуудал хангалтгүй байгааг Олон Улсын Төсвийн түншлэл (IBP) онцолсон.

Иймд төсвийн төсөл болон түүний өөрчлөлтийг иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр танилцуулах, хөрөнгө оруулалт болон урсгал зардлын дэлгэрэнгүй мэдээллийг нээлттэй хүргэх, олон нийтийн саналын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар эргэн тайлагнах, иргэдэд зориулсан төсвийн товч танилцуулгыг тогтмол боловсруулж нийтлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага үүсээд байна.

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЕРӨНХИЙ БҮТЭЦ, ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА, ХАМРАХ ХҮРЭЭ

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэхүү хуулийн төслийн зорилго нь улсын төсвийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын бодлого, төсвийн зарцуулалтын ил тод байдал, олон нийтийн оролцоо, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах, төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эдийн засаг, нийгмийн үр өгөөжид суурилан үнэлж эрэмбэлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төрийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлын мэдээллийг олон нийтэд ил тод, ойлгомжтой хэлбэрээр хүргэх, хөгжлийн бодлого болон төсвийн төлөвлөлтийн уялдааг хангахад оршино.

Хуулийн төсөл нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг сонгох, үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааг нэгдсэн шалгуур, онооны аргачлалд үндэслэх, үнэлгээ, эрэмбэ хийгдээгүй төсөл, арга хэмжээг улсын төсөвт тусгахыг хязгаарлах, төсвийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтыг улс төрийн нөлөөллөөс ангид, нотолгоонд суурилсан, ил тод тогтолцоонд шилжүүлэхэд чиглэж байна.

Түүнчлэн төсвийн төслийн танилцуулга, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлын мэдээллийг иргэд, олон нийтэд энгийн ойлгомжтой, харьцуулалт бүхий, хүртээмжтэй хэлбэрээр мэдээлэх, төсвийн төсөлд иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн саналын шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг ил тод тайлагнах, “иргэдийн төсөв” хэлбэрийн хялбаршуулсан танилцуулгын эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилтыг мөн агуулж байна.

Хуулийн төслийн хүрээнд дараах үндсэн харилцааг зохицуулна. Үүнд:

1.Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг урьдчилсан үнэлгээ, оноо, эрэмбэд үндэслэн төсөвт тусгахтай холбоотой харилцаа;

2.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн уялдааг хангахтай холбоотой харилцаа;

3.Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнэлгээ, эрэмбэ, санхүүжилт, хэрэгжилтийн мэдээллийг нээлттэй цахим хэлбэрээр нийтлэхтэй холбоотой харилцаа;

4.Төсвийн урсгал зардлын бүтэц, зориулалт, нэгж өртөг, тоо хэмжээ, үр дүнгийн мэдээллийг нарийвчлан ил тод болгохтой холбоотой харилцаа;

5.Төсвийн төслийг олон нийтэд нээлттэй, ойлгомжтой хэлбэрээр танилцуулах, иргэдийн оролцоог хангах, гаргасан саналын шийдвэрлэлтийг тайлагнахтай холбоотой харилцаа;

6.Төсвийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, төсөвт тусгах ажиллагаанд хуульд заасан үнэлгээ, эрэмбэ, ил тод байдлын шаардлагыг мөрдөөгүй албан тушаалтанд хариуцлага тооцохтой холбоотой харилцаа.

Хуулийн төслийн ерөнхий бүтэц нь Төсвийн тухай хуулийн төсөв боловсруулах шаардлага, улсын хөрөнгө оруулалтын урьдчилсан үнэлгээ, улсын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, олон нийтийн хэлэлцүүлэг, төсвийн төслийн танилцуулга, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлын мэдээллийн агуулга, хариуцлагын зохицуулалттай холбоотой зүйл, хэсгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар боловсруулагдсан.

Энэхүү хуулийн төслийн хамрах хүрээнд улсын төсөв, улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, төсвийн урсгал зардал, төсвийн төсөл

боловсруулах болон хэлэлцүүлэх ажиллагаа, төсвийн мэдээллийн ил тод байдал, олон нийтийн оролцоо, төсвийн мэдээллийн тайлагнал, төсвийн хөрөнгө оруулалтын үнэлгээ, эрэмбэлэлт, түүнтэй холбоотой төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа бүхэлдээ хамаарна.

Хуулийн төсөл батлагдсанаар төсвийн төлөвлөлт илүү нотолгоонд суурилсан, ил тод, хариуцлагатай болох, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг дээшлэх, төсвийн сахилга бэхжих, иргэдийн төсөвт итгэх итгэл нэмэгдэх, төрийн зардлын үр ашиг сайжрах эрх зүйн орчин бүрдэх ач холбогдолтой.

**ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНЫ ДАРАА ҮҮСЧ БОЛОХ
НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, ХУУЛЬ ЗҮЙН ҮР ДАГАВАР,
ХҮРЭХ ҮР ДҮН, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР
АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ САНАЛ**

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын бодлого, төсвийн мэдээллийн ил тод байдал, олон нийтийн оролцоо, төсвийн сахилга хариуцлагын тогтолцоонд нийгэм, эдийн засаг, хууль зүйн олон талт эерэг үр дагавар бий болохоор байна.

Нэгдүгээрт, төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэгдсэн шалгуур үзүүлэлт, оноо, эрэмбэд үндэслэн сонгон шалгаруулах тогтолцоо бүрдсэнээр төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, өгөөж сайжрах нөхцөл бүрдэнэ. Сүүлийн жилүүдэд улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ тогтмол өсөж, 2025 оны улсын төсөвт хөрөнгө оруулалтын зардал 5 их наяд төгрөгөөс давсан хэдий ч хэрэгжилтийн чанар, үр өгөөжтэй холбоотой асуудал тогтмол шүүмжлэл дагуулж байна. Үндэсний Аудитын газрын тайлангуудад техник, эдийн засгийн үндэслэл дутуу, зураг төсөвгүй, санхүүжилтийн эх үүсвэр бүрэн шийдвэрлэгдээгүй, хэрэгжих хугацаа хэтэрсэн, төсөвт өртөг нь нэмэгдсэн төсөл, арга хэмжээ жил бүр нийтлэг илэрч байгаа талаар дурдсан. Тухайлбал, сүүлийн жилүүдийн аудитын тайлангуудаар олон арван төсөл анхны батлагдсан хугацаандаа ашиглалтад ороогүй, төсөвт өртөг нь нэмэгдсэн, зарим тохиолдолд тухайн төслийн хүчин чадал, байршил, хэрэгцээ шаардлагын тооцоо хангалтгүй байсан нь тогтоогдсон.

Улсын төсвийн хоёрдугаар хавсралт буюу Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг хуульд заасан шалгуурын дагуу одоогоор боловсруулж загвар болон энэхүү хуулийн төслийн холбогдох заалтын дагуу өөрчлөгдөх хэлбэрийг зургаар харууллаа.

Зураг 1. Улсын төсвийн хоёрдугаар хавсралт

Төслийн код	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг			сая төгрөг
				Анхны	Сүүлийн	2026 онд	2026 онд санхүүжих дүн
	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД					974,356.1	322,422.8
	I. Барилга байгууламж					884,356.1	252,422.8
	<i>Үргэлжлүүлэн хэрэгжүүлэх</i>					<i>579,661.4</i>	<i>184,572.4</i>
УТ2503000996	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн 2 дугаар хэлхээ, дэд бүтэц /Баянхонгор, Баянхонгор сум/	2025	2027	51,948.9	51,948.9	51,948.9	19,832.9

*Зураг 2. Хавсралтыг шинэчлэх загвар
/Цэнхэр өнгөөр тэмдэглэсэн багануудыг шинээр нэмэх/*

2026 оны хөгжлийн төлөвлөгөө дэх төсөл, арга хэмжээ	Улсын төсөв дэх төсөл, арга, хэмжээний дугаар	Улсын төсөв дэх төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Тухайн төсөл, хөтөлбөр, арга хэмжээ нь хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгод нийцэж байгаа эсэх /Тийм, үгүй/	Зорилгод нийцээгүй үндэслэл	Эхлэх	Дуусах	Хөгжлийн төлөвлөгөө дэх тухайн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нийт санхүүжилт ийн дүн сая. Төг	Төсөвт өртөг			2026 онд санхүүжих дүн	Хөгжлийн төлөвлөгөө дэх 2026 онд санхүүжих дүн	Ирэх жилүүдэд санхүүжих дүн
								Анхны	Сүүлийн	2026 онд			


Төсөл, арга хэмжээг нэгдсэн үнэлгээ, эрэмбэд үндэслэн сонгох эрх зүйн орчин бүрдсэнээр төсвийн хөрөнгө оруулалтын шийдвэр илүү нотолгоонд суурилсан, үр ашигт чиглэсэн, улс төрийн нөлөөллөөс ангид болох нөхцөл бүрдэнэ. Ингэснээр төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг нэмэгдэж, төсвийн хөрөнгө оруулалт царцах, хугацаа хэтрэх, төсөвт өртөг өссөн төслийн тоо буурах эерэг үр дүн гарна.

Хоёрдугаарт, төсвийн урсгал зардлын мэдээллийг зардлын нэр төрөл, зориулалт, нэгж өртөг, тоо хэмжээ, зорилтот бүлэг, хэрэгжилтийн үр дүнтэй уялдуулан ил тод болгох зохицуулалт хэрэгжсэнээр төсвийн сахилга, хариуцлага сайжирна. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагад урсгал зардлын эзлэх хувь сүүлийн жилүүдэд тогтмол өндөр хэвээр байгаа бөгөөд 2025 оны улсын төсөвт урсгал зардал нийт зарлагын дийлэнх хувийг бүрдүүлж байна. Цалин хөлс, бараа үйлчилгээ, татаас, шилжүүлэг зэрэг урсгал шинжтэй зардлын өсөлт нь төсвийн дарамтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хөрөнгө оруулалтын боломжийг хязгаарлах эрсдэл үүсгэж байна.

Одоогийн нөхцөлд урсгал зардлын бүтэц, тооцоолол, нэгж өртөг, үр дүнгийн мэдээлэл олон нийтэд хангалттай нээлттэй биш байгаа нь төсвийн үр ашиггүй зарцуулалт, давхардал, тансаг хэрэглээний шинжтэй зардлыг хянах боломжийг хязгаарлаж байна. Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар төсвийн урсгал зардлын төлөвлөлт, зарцуулалтад олон нийтийн болон парламентын хяналт сайжирч, үр ашиггүй зардлыг бууруулах, төсвийн сахилга бэхжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Гуравдугаарт, төсвийн төсөл болон хөрөнгө оруулалтын мэдээллийг иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр танилцуулах, олон нийтийн оролцоог бодитой хангах эрх зүйн үндэс бүрдсэнээр төсвийн ил тод байдал, иргэдийн төрд итгэх итгэл нэмэгдэх ач холбогдолтой. Олон улсын Төсвийн нээлттэй байдлын судалгаагаар төсвийн ил тод байдал өндөр улс орнуудад төсвийн сахилга, хөрөнгө оруулалтын үр ашиг, авлигын эсрэг үр нөлөө харьцангуй сайн байдаг талаар дурдсан байдаг. Монгол Улсын хувьд төсвийн мэдээлэл нийтлэгддэг боловч иргэдэд ойлгомжтой, харьцуулалт бүхий, энгийн тайлбар хэлбэрээр тогтмол хүргэх тогтолцоо хангалтгүй хэвээр байна. Энэхүү саналыг ойлгомжтой харуулах зорилгоор Эрчим хүчний салбарын 2026 оны төсвийн зарим үзүүлэлтийг зургаар үзүүлэв.

Зураг 3. Эрчим хүчний салбарын төсвийн бүтэц



Сүүлийн жилүүдэд Засгийн газар болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн төсөлтэй холбоотой олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж байгаа боловч эдгээр нь ихэвчлэн танилцуулах шинжтэй явагдаж, иргэдийн гаргасан санал төсөвт хэрхэн туссан талаарх эргэн мэдээлэх, тайлагнах зохицуулалт сул хэвээр байна. Хуулийн төсөл батлагдсанаар иргэдийн санал хэрхэн шийдвэрлэгдсэнийг ил тод тайлагнах, иргэдэд зориулсан төсөв хэлбэрийн танилцуулгыг тогтмол боловсруулах, төсвийн мэдээллийг нээлттэй цахим хэлбэрээр байршуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөвдүгээрт, төсвийн хөрөнгө оруулалтын үнэлгээ, эрэмбэ, санхүүжилт, хэрэгжилтийн мэдээллийг нээлттэй цахим хэлбэрээр байршуулах нь авлига, ашиг сонирхлын зөрчил, улс төрийн нөлөөлөлтэй холбоотой эрсдэлийг бууруулах ач холбогдолтой. Төсвийн хөрөнгө оруулалтын сонгон шалгаруулалт ил тод бус, бодит эрэмбэ, үнэлгээгүй байх нь төсвийн үр ашиггүй зарцуулалт, төсөл сонголтын улс төржилтийг нэмэгдүүлдэг талаар олон улсын байгууллагууд дүгнэж ирсэн. Иймд төсөл сонголтын үндэслэл, оноо, эрэмбэ, санхүүжилтийн мэдээллийг нээлттэй болгосноор олон нийтийн болон мэргэжлийн хяналт сайжирна.

Тавдугаарт, энэхүү хуулийн төсөл батлагдсанаар төсвийн төлөвлөлт болон хөгжлийн бодлогын уялдаа сайжирч, хөгжлийн зорилт, улсын төсөв хоорондын холбоо илүү бодитой болно. Одоогийн нөхцөлд хөгжлийн бодлогын баримт бичигт туссан зарим төсөл, арга хэмжээ төсөвтэй бүрэн уялдахгүй байх, эсхүл төсөвт туссан зарим төсөл хөгжлийн бодлогын эрэмбэ, шаардлагатай бүрэн нийцэхгүй байх асуудал ажиглагддаг. Төсөл, арга хэмжээг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, үнэлгээ, эрэмбэд суурилан төсөвт тусгах тогтолцоо нь төсвийн бодлогын тогтвортой байдал, хөгжлийн бодлогын хэрэгжилтийг сайжруулна.

Хуулийн төсөл батлагдсантай холбоотойгоор төсвийн мэдээллийн нэгдсэн

цахим санг шинэчлэх, төсвийн хөрөнгө оруулалтын үнэлгээ, эрэмбэлэлтийн аргачлал боловсруулах, холбогдох төрийн байгууллагын албан хаагчдыг сургах, мэдээллийн системийн чадавхыг сайжруулах, иргэдэд зориулсан төсвийн танилцуулгын загвар, аргачлалыг батлах зэрэг зохион байгуулалтын болон техникийн арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Мөн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үнэлэх нэгдсэн шалгуур үзүүлэлт, жинлэсэн онооны аргачлалыг олон улсын нийтлэг жишиг, тухайлбал Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн “Public Investment Management Assessment (PIMA)” аргачлал, OECD-ийн төсвийн засаглалын зарчимтай нийцүүлэн боловсруулах, хэрэгжилтэд нь тогтмол үнэлгээ хийх шаардлагатай гэж үзэж байна.

ХУУЛЬ ЗҮЙН НИЙЦЭЛ, ШИНЭЭР ҮҮСЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн санхүү, төсвийн ил тод, хариуцлагатай, иргэдийн оролцоотой байх зарчим, хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтвортой байдлыг хангах агуулгатай нийцэж боловсруулагдсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д Улсын Их Хурал нь “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах” бүрэн эрхтэй байхаар заасан. Мөн “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна”, “Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно”, “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж тус тус хуульчилсан нь төсвийн төлөвлөлт, хяналт, ил тод байдал, үр ашиг, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх суурь зарчим болж байна.

Хуулийн төсөл нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны Хөгжлийн бодлоготой нийцэж байна. Тус бодлогын Засаглал бүлэгт төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх, төсөв, санхүүгийн удирдлагыг олон нийтийн хяналттай болгох, төрийн үйлчилгээний үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх, хөгжлийн бодлого, төсөв хоорондын уялдааг хангах зорилтыг дэвшүүлсэн. Энэхүү хуулийн төсөлд төсвийн хөрөнгө оруулалтын төслийг оноогоор үнэлж эрэмбэлэх, төсвийн мэдээллийг иргэдэд ойлгомжтой хэлбэрээр ил тод болгох, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, урсгал зардлын нарийвчилсан мэдээллийг нээлттэй болгох зэрэг зохицуулалт тусгасан нь дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэж байна.

Түүнчлэн Монгол Улсын Шинэ сэргэлтийн бодлогын Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд төрийн зардлын үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийн сахилга, хариуцлагыг сайжруулах зорилтууд дэвшүүлсэн бөгөөд энэхүү хуулийн төсөл нь эдгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангахад чиглэж байна.

Хуулийн төсөл нь Төсвийн тухай хуульд суурилсан төсвийн төлөвлөлт, төсвийн хөрөнгө оруулалт, олон нийтийн оролцоо, төсвийн мэдээллийн ил тод

байдлыг нарийвчлан сайжруулах агуулгатай бөгөөд уг хуулийн дараах зарчим, зохицуулалттай уялдаж байна. Үүнд:

Төсвийн тухай хуулийн

- 6 дугаар зүйлд заасан Төсвийн ил тод, хариуцлагатай байх зарчим;
- 27 дугаар зүйлд заасан Төсвийн төсөл боловсруулах шаардлага;
- 28 дугаар зүйлд заасан Улсын хөрөнгө оруулалтын төлөвлөлт;
- 281 дүгээр зүйлд заасан Төсвийн төслийн олон нийтийн хэлэлцүүлэг;
- 32 дугаар зүйлд заасан Төсвийн төслийн танилцуулгын агуулга;
- 70 дугаар зүйлд заасан Төсвийн сахилга, хариуцлагын зохицуулалт.

Хуулийн төсөл нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуультай мөн уялдсан. Тус хуульд Хөгжлийн бодлого, төлөвлөлт болон төсвийн төлөвлөлтийн нэгдмэл байдлыг хангах, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилан төсөв боловсруулах, Төсвийн хөрөнгө оруулалтыг хөгжлийн бодлоготой уялдуулах шаардлагыг тусгасан байдаг. Энэхүү хуулийн төсөлд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан оноогоор үнэлж эрэмбэлэх зохицуулалт тусгасан нь дээрх хуультай нийцэж байна.

Түүнчлэн энэхүү хуулийн төсөл нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан төрийн байгууллагын мэдээллийг иргэдэд нээлттэй, хүртээмжтэй хүргэх зарчимтай нийцэж байна. Төсвийн хөрөнгө оруулалтын үнэлгээ, эрэмбэ, санхүүжилтийн мэдээллийг цахим хэлбэрээр нийтэд нээлттэй байршуулах, төсвийн хялбаршуулсан товч танилцуулга боловсруулах зэрэг зохицуулалт нь төсвийн мэдээллийн ил тод байдлыг шинэ түвшинд хүргэх ач холбогдолтой.

Олон улсын түвшинд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилтын 16 дугаар зорилтод “үр нөлөөтэй, хариуцлагатай, ил тод бүтцийг бүх түвшинд бий болгох” зорилтыг дэвшүүлсэн байдаг. Мөн Олон Улсын Валютын сангийн “Fiscal Transparency Code”, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын “Budget Transparency Toolkit”, “Open Budget Survey”-ийн шалгуур үзүүлэлтүүдэд төсвийн ил тод байдал, иргэдийн оролцоо, төсвийн мэдээллийн хүртээмжийг чухалчилдаг. Энэхүү хуулийн төсөл нь эдгээр олон улсын нийтлэг зарчим, сайн туршлагатай нийцэж байна.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах эрх зүйн баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулах шаардлага үүсэж болзошгүй гэж үзэж байна.

- Засгийн газрын тухай хууль болон Засгийн газрын хуралдааны журамд төсвийн хөрөнгө оруулалтын үнэлгээ, эрэмбийн зохицуулалтыг нийцүүлэх;
- Сангийн сайдын баталсан улсын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэлэх аргачлалыг шинэчлэн боловсруулах;
- Төсвийн төсөл боловсруулах, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, төсвийн хялбаршуулсан танилцуулга боловсруулахтай холбоотой журмуудыг шинэчлэн батлах;
- Шилэн дансны тухай хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг төсвийн мэдээллийн шинэ шаардлагатай уялдуулан сайжруулах;
- Төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн нэгдсэн цахим сан, үнэлгээг бий болгохтой холбоотой дүрэм, аргачлал, журмыг батлах.

Энэхүү хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг бүхэлд нь хүчингүй болсонд тооцох шаардлага үүсэхгүй бөгөөд холбогдох журам, аргачлал, зарим журмыг шинэчлэн боловсруулах замаар хэрэгжилтийг хангах боломжтой гэж үзэж байна.